**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2023/132/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 92

танай ______________-ны №______________ -т

ХАНБОГД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАДАМСҮРЭН
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ханбогд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзалгүй ур чадварын нэмэгдэл цалин олгосон, албан хаагчдад түлээ нүүрсний дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас олгосон зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

016020163

## Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь төсвийн хөрөнгөөр 50.8 сая, Говийн Оюу дэмжих сангийн хандиваар 31.4 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 177.5 сая, нийт 259.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, номын фондыг шинээр бэлтгэж, сургалтын бааз суурийг нэмэгдүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах санхүүжүүлэх аргачлал”-ын дагуу жилийн эцсийн дансны үлдэгдэл 17.6 сая төгрөгийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **114,526,690.38** | **125,084,801.10** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 17,585,979.72 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 17,585,979.72 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 17,585,979.72 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 17,585,979.72 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 114,526,690.38 | 107,498,821.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 5,135,500.00 | 10,495,765.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,840,500.00 | 10,495,765.00 |
| | | | |
| **354** | **Хангамжийн материал** | 109,391,190.38 | 97,003,056.38 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,304,046.80 | 1,987,046.80 |
| 35420 | Аж ахуйн материал | 85,872,623.58 | 77,679,009.58 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 38,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,239,100.00 | 779,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,975,420.00 | 16,520,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,332,156,047.90** | **2,420,266,137.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,332,156,047.90 | 2,420,266,137.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,992,245,247.86 | 2,031,309,937.13 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,970,043,925.36 | 1,965,179,012.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -260,343,220.36 | -354,066,975.72 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,575,000.00 | 62,575,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -10,929,166.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 160,497,531.00 | 299,210,701.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -59,196,565.58 | -68,712,430.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 162,434,391.13 | 178,977,617.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -101,700,268.45 | -70,809,499.87 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 43,828,100.00 | 40,026,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -27,817,499.88 | -32,021,199.84 |
| 39217 | Ном | 31,923,854.64 | 21,880,378.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 339,910,800.04 | 388,956,200.04 |
| 39301 | Програм хангамж | 1,296,000.00 | 1,746,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -125,199.96 | -299,799.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 338,740,000.00 | 387,510,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,446,682,738.28** | **2,545,350,938.27** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **492,055.41** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 492,055.41 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 492,055.41 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 492,055.41 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,446,682,738.28** | **2,544,858,882.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,446,682,738.28 | 2,544,858,882.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 803,100,145.30 | 803,100,145.30 |
| 51101 | Өмч: - төрийн | 803,100,145.30 | 803,100,145.30 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 980,906,738.70 | 1,080,097,796.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 980,906,738.70 | -1,464,761,086.86 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 2,544,858,882.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 662,675,854.28 | 661,660,941.56 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,446,682,738.28** | **2,545,350,938.27** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,154,695,402.74** | **4,308,001,720.75** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **160,408,355.74** | **2,748,546,988.75** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 160,408,355.74 | 2,740,575,513.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,598,220.00 | 62,612,788.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,598,220.00 | 3,842,788.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 58,770,000.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 7,971,475.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,971,475.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **203,575,647.00** | **309,472,932.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 790,711,400.00 | 1,249,981,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,743,947.00 | 49,162,232.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,913,710.00 | 37,387,232.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,020,237.00 | 11,775,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,810,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 162,831,700.00 | 260,310,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 162,831,700.00 | 260,310,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,143,767,231.66** | **1,730,874,371.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,143,767,231.66** | **1,730,874,371.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,095,450,218.99 | 1,554,414,407.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 681,294,277.33 | 970,364,560.28 |
| 210101 | Үндсэн цалин | 399,032,051.00 | 671,805,295.28 |
| 210102 | Нэмэгдэл | 206,733,815.40 | 251,620,988.00 |
| 210104 | Урамшуулал | 75,528,410.93 | 46,938,277.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,983,900.00 | 127,685,255.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,034,000.00 | 87,207,655.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,579,600.00 | 10,119,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 631,800.00 | 8,095,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 158,800.00 | 2,024,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,579,700.00 | 20,238,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 138,812,562.00 | 157,482,446.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,007,834.00 | 10,976,118.14 |
| 210302 | Түлш, халаалт | 127,543,206.00 | 127,543,208.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,261,522.00 | 18,963,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,022,549.20 | 59,299,696.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,432,455.20 | 11,228,780.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,055,500.00 | 3,212,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 460,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,689,664.00 | 9,759,093.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 35,099,823.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,600,265.00 | 13,719,300.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,294,000.00 | 444,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,306,265.00 | 13,274,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,748,916.00 | 5,481,742.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,748,916.00 | 5,481,742.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 224,000.00 | 482,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 482,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 263,500.00 | 13,582,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 263,500.00 | 3,843,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 9,738,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 162,500,249.46 | 206,316,907.48 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,509,550.00 | 16,596,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 150,990,699.46 | 189,720,207.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 48,317,012.67 | 176,459,963.76 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,172,470.00 | 125,497,332.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,028,760.00 | 106,478,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,143,710.00 | 19,018,832.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 20,144,542.67 | 50,962,631.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,144,542.67 | 48,126,131.76 |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,928,171.08** | **2,577,127,349.58** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 32,268,466.72 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 32,268,466.72 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -32,268,466.72 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **10,928,171.08** | **2,544,858,882.86** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **996,885,267.00** | **1,571,268,995.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,598,220.00** | **11,814,263.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,598,220.00 | 3,842,788.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,598,220.00 | 3,842,788.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,598,220.00 | 3,842,788.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 7,971,475.00 |
| 123004 | Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,971,475.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **994,287,047.00** | **1,559,454,732.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 790,711,400.00 | 1,249,981,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,743,947.00 | 49,162,232.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,913,710.00 | 37,387,232.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,020,237.00 | 11,775,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,810,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 162,831,700.00 | 260,310,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 162,831,700.00 | 260,310,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **996,885,267.00** | **1,502,869,015.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **996,885,267.00** | **1,502,869,015.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **948,568,254.33** | **1,327,880,751.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 681,295,077.33 | 970,364,560.28 |
| 210101 | Үндсэн цалин | 399,032,851.00 | 671,805,295.28 |
| 210102 | Нэмэгдэл | 206,733,815.40 | 251,620,988.00 |
| 210104 | Урамшуулал | 75,528,410.93 | 46,938,277.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,983,100.00 | 127,193,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,034,000.00 | 86,715,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,579,600.00 | 10,119,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 631,800.00 | 8,095,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 158,000.00 | 2,024,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,579,700.00 | 20,238,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 138,812,562.00 | 157,482,446.24 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,007,834.00 | 10,976,118.14 |
| 210302 | Түлш, халаалт | 127,543,206.00 | 127,543,208.10 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,261,522.00 | 18,963,120.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,373,130.00 | 660,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,861,200.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,055,500.00 | 660,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,384,930.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 460,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,111,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,446,105.00 | 10,814,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,723,200.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 662,905.00 | 10,814,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,060,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,235,500.00 | 5,519,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,560,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,675,500.00 | 5,519,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 800,000.00 | 12,082,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,000.00 | 2,343,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 9,738,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,398,780.00 | 43,763,845.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 27,426,045.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,398,780.00 | 16,337,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,317,012.67** | **174,988,263.76** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,172,470.00 | 124,025,632.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,028,760.00 | 105,006,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,143,710.00 | 19,018,832.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 50,962,631.76 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 48,126,131.76 |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,144,542.67 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **68,399,979.72** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **50,814,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **50,814,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 50,814,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 50,814,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-50,814,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 17,585,979.72 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 17,585,979.72 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **803,100,145.30** | **662,675,854.28** | **980,906,738.70** | 2,446,682,738.28 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -2,445,667,825.56 | -2,445,667,825.56 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **803,100,145.30** | **662,675,854.28** | **-1,464,761,086.86** | 1,014,912.72 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,014,912.72 | 00.00 | -1,014,912.72 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 2,544,858,882.86 | 2,544,858,882.86 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **803,100,145.30** | **661,660,941.56** | **1,080,097,796.00** | 2,544,858,882.86 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,249,981,800.00 | 1,240,367,295.28 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,249,981,800.00 | 1,240,367,295.28 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,154,410,400.00 | 1,150,892,395.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 930,279,800.00 | 926,789,450.28 |
| 210101 | Үндсэн цалин | 691,674,200.00 | 636,225,037.28 |
| 210102 | Нэмэгдэл | 214,813,100.00 | 246,013,014.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 23,792,500.00 | 44,551,399.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,884,800.00 | 117,743,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,161,800.00 | 80,065,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,430,700.00 | 9,419,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,544,600.00 | 7,535,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,886,100.00 | 1,884,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,861,600.00 | 18,838,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,814,800.00 | 10,814,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,814,800.00 | 10,814,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,782,500.00 | 12,082,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 2,343,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,782,500.00 | 9,738,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 85648500.00 | 83462845.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,974,800.00 | 68,790,045.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,673,700.00 | 14,672,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 95571400.00 | 89474900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 95,571,400.00 | 89,474,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 95,571,400.00 | 89,474,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,249,981,800.00 | 1,249,981,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,249,981,800.00 | 1,249,981,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,249,981,800.00 | 1,249,981,800.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 17,585,979.72 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **49,162,232.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,162,232.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,775,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 660,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 660,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,115,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,115,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 34,550,732.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,550,732.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,531,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,018,832.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,836,500.00 |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,836,500.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 49,162,232.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,162,232.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,387,232.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,775,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.9 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 7.9 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн үлдэгдэл, БШУЯ-аас ирсэн санхүүжилтийн орлогыг мөнгөн гүйлгээ, орлого үр дүнгийн тайланд 120010 борлуулалтын орлого дансанд бүртгэсэн байна

Аудитаар нийт 46.8 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 14.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тус сургуулийн захирлын 2022 оны Б/86 дугаар тушаалаар албан хаагчдад түлш худалдан авах дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас 12 дугаар сард 14,100,000 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 */батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/,* Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "*Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"*-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

Тус сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн харгалзалгүй нийтдээ 32,699,879 төгрөгийг ур чадварын нэмэгдэл цалинг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 *"байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох*", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дугаар тушаалаар баталсан *"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт*", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар баталсан "*Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам*"-ын 5-д заасантай тус тус нийцэхгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт 1:* Тус цэцэрлэгийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж буй шинээр баталсан Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэн боловсруулаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ"-д заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлж "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн батлуулж ажиллах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт 2:* Захирлын 2022 оны А/22 дугаар тушаалаар "Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогын комисс байгуулах"-даа багийн бүрэлдэхүүнд нягтлан бодогчийн томилсон, тооллогын үр хэлэлцээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72 дугаар зүйлд заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид хүлээлгэн өгч нягтлан бодох бүртгэлд тусгуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн үлдэгдэл, БШУЯ-аас ирсэн санхүүжилтийн орлогыг мөнгөн гүйлгээ, орлого үр дүнгийн тайланд 120010 борлуулалтын орлого дансанд бүртгэсэн байна. | 1 | 7,971.5 | | | 1 | 7,971.5 | 1 | 7,971.5 | | | | |
| **Дүн** | **1** | **7,971.5** | | | **1** | **7,971.5** | **1** | **7,971.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тус цэцэрлэгийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж буй шинээр баталсан Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж шинэчлэн боловсруулаагүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Захирлын 2022 оны А/22 дугаар тушаалаар "Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогын комисс байгуулах"-даа багийн бүрэлдэхүүнд нягтлан бодогчийн томилсон, тооллогын үр хэлэлцээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Тус сургуулийн багш, ажилчдад шалгуур үзүүлэлтгүй, ажлын гүйцэтгэл үр дүн | 1 | 32,699.8 | | | 1 | 32,699.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| харгалзалгүй нийтдээ 32,699,879 төгрөгийг ур чадварын нэмэгдэл нэмэгдэлд олгосон байна. | | | | | | | | | | | | |
| Тус сургуулийн захирлын 2022 оны Б/86 дугаар тушаалаар албан хаагчдад түлш худалдан авах дэмжлэг үзүүлэхдээ цалин хөлсний зардлаас 14,100,000 төгрөгийг олгосон байна. | 1 | 14,100.0 | 1 | 14,100.0 | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **46,799.8** | **1** | **14,100.0** | **1** | **32,699.8** | **2** | **0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бөгөөд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 67,619,230 төгрөгийн 2 ажил гүйлгээ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг оруулаагүй байна. | 1 | 67,619.2 | | | | | 1 | 67,619.2 |
| Дүн | 1 | 67,619.2 | | | | | 1 | 67,619.2 |